



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ИЖИЛ САНАА ӨЭМТ-ИЙН 2025 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: НТАГ-2026/114/НА-СТА-ОНӨҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Улаанбаатар хот 2026 он</p>	<p>НТАГ-ын дарга, тэргүүлэх аудитор Г.Нандинжаргал Утас:327734 Цахим хаяг:nandinjargalg@audit.gov.mn</p> <p>Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер Х.Түвшинбаяр Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер:С.Гантөгс Утас: 315558 Цахим хаяг: gantugss@audit.gov.mn</p> <p>Ашид баланс аудит ХХК-ийн захирал:Л.Майцэцэг Утас: 99081568 Цахим хаяг:ashidbalance@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

№ 03.15 № 874
танай _____-ны № _____-т

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ИЖИЛ
САНАА ӨЭМТ-ИЙН ДАРГА
Б.АЗЗАЯА ТАНАА

Хязгаарлалтай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.4, 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.2, 8.4, Төсвийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.6-д заасны дагуу Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Ижил санаа ӨЭМТ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Ижил санаа ӨЭМТ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн 61.4 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн “эрх ба үүрэг”, “иж бүрэн байх”, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус төв нь эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай сэргээн засах үйлчилгээ, гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээ, оношилгоо шинжилгээ, өдрийн эмчилгээ гэсэн 4 төрлийн тусламж үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулан Эрүүл мэндийн даатгалын сангаас нэг иргэнд ногдох зардлын санхүүжилтээр 602.3 сая төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлэн ажилласан байна.

Аудитын гол асуудал

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хяналт, санхүүжилт, төлбөр тооцооны программ, цахим системийг бодит цагийн горимд шилжүүлж, иргэнд чанартай эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чирэгдэлгүй үзүүлж гүйцэтгэлд суурилсан санхүүжилтээр үйл ажиллагаагаа явуулах эрх зүйн шинэчлэл хийгдсэн байна.

C:\Users\inarangua\Desktop\Бичиг хэргийн 2026\03\Бичиг хэргийн 2026\03\03.15\03.15.0874.docx
1426050853

Бусад асуудлын хэсэг

Тус төв нь Health.gov.mn программыг ӨЭМТ-ийн үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлэн, ӨЭМТ-ийн дарга, их эмч, сувилагч, бүртгэл мэдээллийн ажилтан зэрэг нийт 12 албан хаагч байнгын ашиглаж байна.

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Ижил санаа ӨЭМТ-ийн 2025 оны гүйцэтгэлийн гэрээний биелэлтийг Нийслэлийн Засаг даргын 2026 оны А/47 захирамжаар 94.0 хувь, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ, худалдан авах даатгалын гэрээний биелэлтийг 98.4 хувийн хэрэгжилттэй гэж үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд Аудитын олон улсын стандартын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ХӨРӨНГИЙН ДҮН		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	9,302,020.80	585,325.05
1.1.2	Авлага	40,582,582.39	8,947,626.97
1.1.6	Бараа материал	7,516,305.36	6,742,123.36
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	57,400,908.55	16,275,075.38
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	41,886,653.27	56,480,656.04
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	41,886,653.27	56,480,656.04
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	99,287,561.82	72,755,731.42
2	Өр төлбөр ба эздийн өмч		
2.1	Өр төлбөр	-	-
2.1.1	Дансны өглөг	-	17,045,819.85
2.2	Өр төлбөрийн дүн	-	17,045,819.85
2.3	Эздийн өмч	82,086,241.76	82,086,241.76
2.3.1	Өмч-төрийн	82,086,241.76	82,086,241.76
2.3.9	Хуримтлагдсан үр дүн	17,201,320.06	17,201,320.06
2.3.10	Тайлант үеийн үр дүн		(26,531,830.40)
2.3.11	Эздийн өмчийн дүн	99,287,561.82	72,755,731.42
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ӨМЧ	99,287,561.82	72,755,731.42

2.2 Аудит хийсэн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Борлуулалтын орлого	571,128,912.50	602,261,283.42
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг		
3	Нийт ашиг /алдагдал/	571,128,912.50	602,261,283.42
5	Хүүгийн орлого	31,030.47	83,312.17
6	Бусад орлого	3,617,578.75	13,756,416.41
10	Ерөнхий ба удирдлагын зардал	565,827,986.29	642,632,842.40
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	8,949,535.43	(26,531,830.40)
19	Орлогын татварын зардал	-	-
20	Татварын дараах ашиг (алдагдал)	8,949,535.43	(26,531,830.40)
22	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал)	8,949,535.43	(26,531,830.40)
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
27	Нийт орлогын дүн	127,648,364.65	(26,531,830.40)
28	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	562,186,470.44	637,132,950.25
1.1.5	Татаас санхүүжилтийн орлого	557,020,094.28	602,261,283.42
1.1.6	Бусад орлого	5,166,376.16	34,871,666.83
1.2	Мөнгөн зарлагын дүн	556,843,359.00	635,734,488.17
1.2.1	Ажиллагсад төлсөн	340,227,069.89	346,544,729.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	26,413,051.64	40,870,641.24
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	122,167,814.04	131,457,755.86
1.2.9	Бусад мөнгөн зардал	68,035,423.43	116,861,362.07
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	5,343,111.44	1,398,462.08
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	(2,052,000.00)	(10,115,157.83)
2.1	Мөнгөн орлогын дүн (+)		83,312.17
2.1.6	Хүүгийн орлого		83,312.17
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	2,052,000.00	10,198,470.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	2,052,000.00	10,198,470.00
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
4	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	3,291,111.44	(8,716,695.75)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	6,010,910.26	9,302,020.80
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	9,302,020.80	585,325.05

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	82,086,241.76	8,176,184.63	88,117,628.69
Залруулсан үлдэгдэл	82,086,241.76	8,176,184.63	88,117,628.69
Тайлант үеийн ашиг (алдагдал)		9,025,135.43	9,025,135.43
2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	82,086,241.76	17,201,320.06	99,287,561.82
Залруулсан үлдэгдэл	82,086,241.76	17,201,320.06	99,287,561.82
Тайлант үеийн ашиг (алдагдал)		(26,531,830.40)	(26,531,830.40)
2025 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	82,086,241.76	(9,330,510.34)	72,755,731.42

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Оны эхний үлдэгдэл ХХОАТ-ын авлага 6,478.0 мянган төгрөгийг бүртгээгүй, тайлант хугацааны эцэст татварын авлагыг 169.2 мянган төгрөгийг дутуу тайлагнасан нийт 6,647.2 мянган төгрөгийн алдаа гарч байна.	1	6,647.2	-	-	1	6,647.2	1	6,647.2	-	-	-	-
Дүн	1	6,647.2			1	6,647.2	1	6,647.2	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Бараа материалын 56,428.8 мянган төгрөгийн худалдан авалт хийхдээ анхан шатны баримтын иж бүрдэл дутуу и	1	56,428.8			1	56,428.8						

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Ижил санаа ӨЭМТ-ийн 2025 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын дүгнэлт

баримтгүй гүйлгээ хийсэн нь өмнөх аудитаар илэрч байсан зөрчил давтагдаж байна.												
Ажилчдад олгосон шагнал, урамшуулалаас 4,990.2 мянган төгрөгийн татварыг суутган тооцсон боловч татварын албатай тооцоо хийгээгүй байна.	1	4,990.1	-	-	-	-	1	4,990.1	-	-	-	-
Ижил санаа ӨЭМТ-ийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2026 оны 03 дугаар сарын 23-нийн өдрийн 17 дугаартай албан бичгийн хамт аудитын байгууллагад хугацаа хоцроож ирүүлсэн.	1	-			1	-						
Санхүүгийн программ "aculus" нь шаардлага хангахгүй, хөгжүүлэлт, шинэчлэлтийг тогтмол хийлгэдэггүй байна. Тухайлбал оны эхний үлдэгдэл буруу татагдах, стауст хөрвүүлэхэд алдаа гарч байна.	1	-	-	-	-	-	1					
Дүн	4	61,418.9	-	-	2	56,428.8	2	4,990.1	-	-	-	-